

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/4/НА-СТА-ТӨА

<p>www.audit.mn</p> <p>Чингис хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112</p> <p>Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390</p> <p>Ахлах аудитор: Г.Энх-Амгалан Утас: 91119424</p> <p>Аудитор: Б.Ариунаа Н.Туяа Н.Хэрлэнбаяр Цахим хаяг: www.audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	5
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	10
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	10
<b>5.2 Албан шаардлага</b> .....	10
<b>5.3 Зөвлөмж</b> .....	11
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	13

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨК	Төрийн өмчит компани
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.13 № 463

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- ТӨҮГ-ын Захиргааны ажилтнуудын сар, улирлын ажлын гүйцэтгэлийг үнэлэхгүйгээр 2,029.3 сая төгрөгийн сар, улирлын шагналт цалин олгосон.
- Бараа материалд сүүлийн 3 жилд хөдөлгөөн ороогүй 2,882.5 сая төгрөгийн материалын үлдэгдэл байна.
- Эрдэнэс монгол ХХК-ийн удирдлагын зөвшөөрөлгүйгээр ТӨҮГ-ын баяжуулах фабрикийн дарга, ерөнхий инженер, бүтээмж хариуцсан менежер, хэлтсийн дарга зэрэг албан тушаалтнууд гадаад томилолтоор ажиллаж 41.2 сая төгрөг зарцуулсан.
- Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтөөр оруулсан "Бутлагч алхтай экскаватор"-ыг 1,150.0 сая төгрөгөөр гэрээний дагуу нийлүүлсэн боловч эвдрэлтэй техник ирүүлсэнтэй холбоотойгоор, худалдах, худалдан авах гэрээ нь хэрэгжээгүй, түүнд хяналт тавьж ажиллаагүй.
- "Үйлдвэрлэлийн болон ундны усны зориулалттай шугам хоолойн гэмтлийг засварлах ажил" нэрээр 210.9 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, ган хоолой худалдан авсан байна.

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 909.5 сая төгрөгийн 88 арга хэмжээг шууд худалдан авахаар төлөвлөснөөс тайлант оны эцэст 87.8 сая төгрөгийн 9 арга хэмжээ хэрэгжээгүй байна.
- Тайлант онд 6,964.9 сая төгрөгийн 7 арга хэмжээ /тэсэлгээний цооног ерөмдөх багаж багц 2 Оюу энд эн интернэшнл ХХК, 36 айлын орон сууц Өсөх буян тулга ХХК, өрмийн машин, компрессорын шүүр багц 2 Альфафилтер ХХК, компрессор Линкс майнд солюшн ХХК, HITACHI ZAXIS 870H-3 экскаваторын гидро хуваарилагч Говь экуйлмент рентал флийт ХХК, ажилчдын амрах байрыг буулгаж шилжүүлэн барих Термо элект трейд ХХК, LIEBHERR R966 гидроэкскаваторын их засвар Майнс ап ХХК/ хугацаандаа хэрэгжээгүй, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, арга хэмжээ авч ажиллаагүй, хэрэгжилтийн явцад хяналт тавьдаггүй, гэрээнд заасан алдангийг тооцоогүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1</sup>.2.3. “техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4. "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилгох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", МУ-ын ЗГ-ын 2025 оны 61 дүгээр тогтоолын 5 дахь заалт "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, оновчтой тогтоох, удирдлагын зардал, орон тоог бууруулах зорилгоор зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах ... ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-ын захирлын 2025 А/43 тушаалаар баталсан "Цалин хөлсний журам батлах тухай" журмын 3.6 "УРАМШУУЛАЛ: Үйлдвэрийн газрын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхжүүлэх зорилгоор сар, улирал бүр шагналт цалин болон жилийн үр дүнгийн урамшууллыг олгоно", Засгийн газрын 2025 оны 95 дугаар тогтоолоор баталсан дүрмийн 4.1.6.-д "Үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтан гадаадад албан томилолтоор ажиллах тохиолдолд нэгдлийн толгой компанийн гүйцэтгэх удирдлагаас зөвшөөрөл авч, түүний баталсан удирдамжийн дагуу ажиллана", 5.3-т "Үйлдвэрийн газрын Захирал, газар, хэлтэс, алба, цехийн дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнийг эрх бүхий албан тушаалтанд тооцно." гэсэн заалтуудыг тус тус зөрчиж санхүүгийн тайлагналын, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тус төрийн өмчит үйлдвэрийн газар нь тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 5,774.2 сая төгрөгийн 24 арга хэмжээг нэмж, 16,701.3 сая төгрөгийн 51 арга хэмжээг хасаж, 10,926.6 сая төгрөгөөр бууруулан 3 удаа өөрчлөлт оруулсан, өмнөх оноос дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахгүй орхигдуулсан, төсөвт өртгийн хэмжээг зөрүүтэй тусгасан зэргээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Эрдэнэс монгол ХХК нь "Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-ын жилийн борлуулалтын орлогын 2 хувиар /дээд хэмжээгээр/ төлбөр авахаар

заасан боловч 2024 онд гэрээг дүгнээгүй, 2025 оны гэрээг дүгнэсэн акт үйлдсэн боловч баталгаажуулаагүй, гэрээ дүгнэсэн акт нь үйлчилгээгээ бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг үнэлэх боломжгүй, тайлант онд Эрдэнэс монгол ХХК-иас болон Эрдэнэс монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тус ТӨҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудитыг 2 удаа гүйцэтгэсэн боловч тайланг ирүүлээгүй зэрэг нь менежментийн үйлчилгээ үзүүлэх гол зорилгоо хангахгүй байна.

Эрдэнэс монгол ХХК-тай байгуулсан "Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний төлбөртэй холбоотой 11,247.7 сая төгрөгийн өр үүссэн нь санхүүгийн тайлан дахь дансны өглөгийн 30.8 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд бүтээмжийн менежер, хяналтын менежерээр 2 албан тушаалтныг томилж 451.2 сая төгрөгийн цалин, шагналт цалин олгож Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

"Майнс ап" ХХК-иас 2022 оны эцэст 16 ширхэг өөрөө буулгагч TEREX-TR60 автосамосвалыг 31,069.5 сая төгрөгөөр худалдан авч, ашиглалтын хугацааг 10 жилээр тогтоосон боловч 2025 онд 1 автосамосвал эвдрэлийн улмаас бүрэн хүчин чадлаар ажиллаагүй, 1 автосамосвал бүтэн зогсолт хийж ашиглалтгүй байна. Энэ нь урсгал болон их засварыг өндөр өртөгтэй гүйцэтгүүлэх шаардлага үүсгэж, хөрөнгийн үр ашгийг бууруулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр /

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
А	Б	1	2
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө ба түүнгэй адилтгах хөрөнгө	5,442,815.36	10,153,202.78
1.1.2	Дансны авлага	11,657,808.62	7,968,738.15
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	8,871,198.34	9,099,874.74
1.1.4	Бусад авлага	4,617,881.07	6,413,917.14
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	131,779,308.08	101,386,499.82
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	14,661,920.59	6,866,509.89
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	9,658,526.25	4,657,792.87
1.1.10		-	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>186,689,458.31</b>	<b>146,546,535.40</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	139,242,376.32	186,818,019.62
1.2.2	Биет бус хөрөнгө	5,777,958.63	7,740,571.68
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	8,323,962.99	12,623,128.97
1.2.6	Уул уурхайн хөрөнгө	139,428,356.66	158,894,898.64
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,960.80	439,281.91
1.2.8	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.9	Бусад эргэлтийн бус хөрөнгө	14,448,746.89	14,454,321.89
1.2.10	Дуусаагүй барилга	1,033,778.70	1,033,778.70
1.2.11	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>308,257,140.99</b>	<b>382,004,001.42</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>494,946,599.31</b>	<b>528,550,536.82</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>	-	-
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	47,298,741.96	36,293,245.44
2.1.1.2	Цалингийн өглөг	3,674,452.13	4,901,975.53
2.1.1.3	Татварын өр	50,941,566.81	24,391,785.71
2.1.1.4	НДШ-ийн өглөг	914,157.17	133,746.88
2.1.1.5	Богино хугацаат зээл	34,189,401.50	22,716,035.74
2.1.1.6	Хүүний өглөг	25,852.81	15,517.81
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	23,383,320.00	23,383,320.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	107,337,752.40	206,499,531.96
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	2,725,880.89	3,166,035.23
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	7,517,979.66	521,191.85
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12		-	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>278,009,105.34</b>	<b>322,022,386.15</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	355,803.69	355,803.69
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	8,800.00	8,800.00
2.1.2.5		-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>364,603.69</b>	<b>364,603.69</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>278,373,709.03</b>	<b>322,386,989.84</b>
<b>2.3</b>	<b>2. Эзэмшигчдийн өмч</b>	-	-
2.3.1	Өмч : а) төрийн	1,226,788.00	1,226,788.00
2.3.2	б) хувийн	-	-
2.3.3	в) хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	50,800,617.43	50,800,617.43
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,641,413.04	2,641,413.04
2.3.9	Тусгай зориулалтын нөөц сан	-	-
2.3.10	Хуримтлагдсан ашиг	161,904,071.81	151,494,728.52
2.3.10.1	Тайлангийн үеийн	25,717,701.93	4,734,050.29
2.3.10.2	Өмнөх үеийн	136,186,369.88	146,760,678.23
2.3.11		-	-
<b>2.3.20</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>216,572,890.28</b>	<b>206,163,546.98</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>494,946,599.31</b>	<b>528,550,536.82</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх тайлант үеийн дүн 2024.12.31	Тайлант жилийн дүн
<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	295,226,284.40	327,842,275.50
Борлуулалтын өртөг	141,725,429.36	208,454,778.06
<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	153,500,855.04	119,387,497.44
Түрээсийн орлого	131,439.56	708,701.07
Хүүгийн орлого	18,592.92	34,145.73
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	16,575,926.19	43,133,911.96
Борлуулалт, маркетингийн зардал	81,621,095.57	91,671,134.85
Ерөнхий ба удирдлагын зардал	14,586,458.77	16,622,220.03
Санхүүгийн зардал	4,689,704.69	4,091,931.26
Бусад зардал	32,423,365.20	32,303,867.38
Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	9,740.77	(756,733.54)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	(7,420.14)	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз )	-	-
Бусад ашиг ( алдагдал )	-	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	36,908,510.11	17,818,369.14
	-	-
	-	-
Орлогын татварын зардал	11,190,808.17	13,084,318.84
<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	25,717,701.93	4,734,050.29
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	25,717,701.93	4,734,050.29
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз ( гарз )	-	-
<b>Орлогын нийт дүн</b>	-	-
<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788.00</b>	-	-	<b>52,631,132.66</b>	-	<b>2,641,413.04</b>	<b>147,268,446.36</b>	<b>203,767,780.05</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	25,717,701.93	25,717,701.93
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-	(4,255,352.46)	(4,255,352.46)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(8,657,239.24)	(8,657,239.24)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(1,830,515.23)	-	-	1,830,515.23	-
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788.00</b>	-	-	<b>50,800,617.43</b>	-	<b>2,641,413.04</b>	<b>161,904,071.81</b>	<b>216,572,890.28</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	4,734,050.29	4,734,050.29
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-	(2,284,542.62)	(2,284,542.62)
Ногдол ашиг	-	-	-	-	-	-	(12,858,850.97)	(12,858,850.97)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788.00</b>	-	-	<b>50,800,617.43</b>	-	<b>2,641,413.04</b>	<b>151,494,728.52</b>	<b>206,163,546.98</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	301,121,821.62	455,883,314.54
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	284,310,796.23	435,924,478.74
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	379,246.11	109,380.56
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	16,431,779.28	19,849,455.24
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	- 275,793,201.21	- 408,822,123.18
1.2.1	Ажилгасад төлсөн	- 69,772,039.16	- 85,064,800.53
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	- 21,659,269.15	- 25,280,012.01
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	- 22,456,980.51	- 20,279,686.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	- 33,099,757.39	- 85,462,832.15
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	- 72,832,968.90	- 97,145,304.90
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	- 4,985,703.26	- 4,103,221.11
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	- 32,747,738.50	- 84,770,086.09
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	- 299,228.13	- 241,418.78
1.2.9	Бусад мөнгөн зарлага	- 17,939,516.21	- 6,474,761.61
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	25,328,620.41	47,061,191.36
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	18,336.25	24,344.38
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	18,336.25	24,344.38
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	- 16,510,049.90	- 17,001,295.32
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	- 16,325,921.54	- 16,809,145.52
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	- 184,128.36	- 192,149.80
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	- 16,491,713.65	- 16,976,950.94
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	- 16,491,713.65	- 16,976,950.94
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	2,600,000.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,600,000.00	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	- 11,257,621.83	- 25,660,974.37
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	- 2,600,382.59	- 12,802,123.40
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	- 8,657,239.24	- 12,858,850.97
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	- 8,657,621.83	- 25,660,974.37
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	137,301.78	287,121.38
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	316,586.71	4,710,387.43
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	5,126,228.65	5,442,815.36
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	5,442,815.36	10,153,202.78

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>			<b>221,882,060.65</b>	<b>265,815,058.15</b>	<b>316,250,971.73</b>	<b>94,368,911.08</b>	<b>142.53</b>	<b>50,435,913.58</b>	<b>118.97</b>
1	Хайлуур жоншны бүтээгдэхүүн	м.төг	1,113,451.19	19,948,952.30	67,522,753.70	66,409,302.51	6,064.28	47,573,801.40	338.48
	Төмрийн баяжмалын бүтээгдэхүүн	м.төг	206,945,653.05	216,214,607.12	231,746,805.15	24,801,152.10	111.98	15,532,198.03	107.18
	Цайрын баяжмалын бүтээгдэхүүн	м.төг	4,875,210.78	-	1,776,120.95	(3,099,089.83)	36.43	1,776,120.95	-
	Төмрийн хүдэр	м.төг	8,947,745.64	8,991,347.89	27,274.13	(8,920,471.51)	0.30	(8,964,073.76)	0.30
	Алт	м.төг	-	20,660,150.84	15,178,017.80	15,178,017.80	-	(5,482,133.04)	73.47
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>311,952,243.07</b>	<b>316,902,930.66</b>	<b>371,719,034.26</b>	<b>59,766,791.19</b>	<b>119.16</b>	<b>54,816,103.60</b>	<b>117.30</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>275,043,732.96</b>	<b>290,928,360.28</b>	<b>353,900,665.12</b>	<b>78,856,932.16</b>	<b>128.67</b>	<b>62,972,304.84</b>	<b>121.65</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	19,276,163.47	18,576,687.20	20,714,151.29	1,437,987.83	107.46	2,137,464.10	111.51
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>36,908,510.11</b>	<b>25,974,570.38</b>	<b>17,818,369.14</b>	<b>(19,090,140.97)</b>	<b>48.28</b>	<b>(8,156,201.24)</b>	<b>68.60</b>
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>25,717,701.93</b>	<b>18,236,554.15</b>	<b>4,734,050.29</b>	<b>(20,983,651.64)</b>	<b>18.41</b>	<b>(13,502,503.86)</b>	<b>25.96</b>
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>81,470,148.20</b>	<b>63,513,478.82</b>	<b>86,685,791.84</b>	<b>5,215,643.63</b>	<b>106.40</b>	<b>23,172,313.02</b>	<b>136.48</b>
	а/ Орлогын татварт	м.төг	11,190,808.17	7,738,016.23	13,084,318.84	1,893,510.67	116.92	5,346,302.61	169.09
	б/ НӨАТ	м.төг	10,120,792.47	7,993,426.80	4,412,249.86	(5,708,542.61)	43.60	(3,581,176.95)	55.20
	в/ НДШ	м.төг	19,679,352.68	15,275,415.27	23,753,073.20	4,073,720.52	120.70	8,477,657.93	155.50
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	6,962,005.03	8,590,167.04	9,060,074.70	2,098,069.67	130.14	469,907.66	105.47
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	301,469.34	328,078.53	323,990.50	22,521.16	107.47	(4,088.03)	98.75
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	26,534.01	28,381.65	31,834.60	5,300.59	119.98	3,452.95	112.17
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	33,189,186.50	23,559,993.30	36,020,250.14	2,831,063.64	108.53	12,460,256.84	152.89
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	<b>23,383,320.00</b>	<b>6,200,428.41</b>	<b>12,858,850.90</b>	<b>(10,524,469.10)</b>	<b>54.99</b>	<b>6,658,422.49</b>	<b>207.39</b>
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	1,644	1,752	1,644	-	100	(108)	93.84
9	Нийт цалингийн сан	м.төг	88,936,475.70	105,165,622.54	96,663,444.05	7,726,968.35	108.69	(8,502,178.49)	91.92
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	4,508.13	5,002.17	4,899.81	391.68	108.69	(102.36)	97.95
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.92	0.94	0.99	0.07	107.60	0.04	104.75
12	Хөрөнгө оруулалт	м.төг	11,916,737.07	30,431,883.36	8,830,152.99	(3,086,584.08)	74.10	(21,601,730.37)	29.02
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>25,146,888.04</b>	<b>2,060,361.90</b>	<b>23,482,530.04</b>	<b>(1,664,358.00)</b>	<b>93.38</b>	<b>21,422,168.14</b>	<b>1,139.73</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	26,560.43	-	-	(26,560.43)	-	-	-
	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>278,373,709.01</b>	<b>171,456,408.70</b>	<b>322,386,989.84</b>	<b>44,013,280.82</b>	<b>115.81</b>	<b>150,930,581.14</b>	<b>188.03</b>
14	Богино хугацаат өр төлбөр	м.төг	278,009,105.33	-	322,022,386.15	44,013,280.82	115.83	322,022,386.15	-
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	364,603.68	-	364,603.68	-	100.00	364,603.68	-

## 2.6 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотгол

/ мянган төгрөгөөр /

Дд	Хөрөнгө оруулалтын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж бүрийн үнэ /мян.төг./	Нийт үнэ /мян.төг./
1	<b>БАРИЛГА БАЙГУУЛАМЖ</b>		<b>9</b>		<b>8,322,760.32</b>
2	<b>АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ</b>		<b>1</b>		<b>480,000.00</b>
3	<b>ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ</b>		<b>79</b>		<b>8,225,486.09</b>
4	<b>КОМПЬЮТЕР, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ</b>		<b>262</b>		<b>581,785.00</b>
5	<b>ТАВИЛГА, АЖ АХУЙН ЭД ХОГШИЛ</b>		<b>281</b>		<b>204,150.00</b>
6	<b>БУСАД ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		<b>2</b>		<b>464,660.00</b>
7	<b>ИХ ЗАСВАРЫН АЖИЛ</b>		<b>537</b>		<b>5,123,768.79</b>
8	<b>ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖИЛ</b>		<b>3</b>		<b>4,631,992.50</b>
9	<b>ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ</b>		<b>17</b>		<b>1,349,400.00</b>
10	<b>ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ</b>		<b>1</b>		<b>1,047,880.66</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>			<b>1,192</b>		<b>30,431,883.36</b>

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дэлгэрэнгүй жагсаалтыг тайланд хавсаргав.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,818.2 сая төгрөгийн 7 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 11,659.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 2,158.7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Бараа материалд сүүлийн 3 жилд хөдөлгөөн ороогүй 2,882.5 сая төгрөгийн материалын үлдэгдэл байна. Энэ нь *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 10/-т “эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах;”, НББОУС 2-ийн 5-т “Бараа материал гэдэгт: а. бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулахаар эзэмшиж байгаа, б. ингэж борлуулахын тулд үйлдвэрлэлийн процесст байгаа. в. үйлдвэрлэлийн процесст эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа ... хөрөнгө юм.”* гэж заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүллээ.*

2. Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтөөр оруулсан "Бутлагч алхтай экскаватор"-ыг 1,150.0 сая төгрөгийн гэрээний дагуу нийлүүлсэн боловч эвдрэлтэй техник ирүүлсэнтэй холбоотойгоор, худалдах, худалдан авах гэрээ нь хэрэгжээгүй, "Үйлдвэрлэлийн болон ундны усны зориулалттай шугам хоолойн гэмтлийг засварлах ажил" нэртэй 210.9 сая төгрөгийн арга хэмжээг тендер шалгаруулалтын нэрээс зөрүүтэйгээр ган хоолойг худалдан авсан, тайлант онд 6,964.9 сая төгрөгийн 7 арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй, гэрээнд заасан алдангийг тооцоогүй зэрэг нь *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-т “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;”, Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ.”, 232 дугаар зүйлийн 232.6-д “Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ.”* гэснийг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүллээ.*

3. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 5,774.2 сая төгрөгийн 24 арга хэмжээг нэмж, 16,701.3 сая төгрөгийн 51 арга хэмжээг хасаж, 10,926.6 сая төгрөгөөр бууруулан 3 удаа өөрчлөлт оруулсан, өмнөх оноос дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахгүй орхигдуулдаг, төсөвт өртгийн хэмжээг зөрүүтэй тусгадаг, төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөхгүй байна. Энэ нь *Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан Төрийн*

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.12-т "Батлагдсан төлөвлөгөөнд дараах тохиолдлоос өөр үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно", 2.12.2-т "энэ журмын 1.7-д заасан захиалагчийн тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл үүссэн" гэж заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.*

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд илэрсэн 451.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг тайлангийн 4.3-т тусгасан болно.

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** ТӨҮГ-ын Захиргааны ажилтнуудын сар, улирлын ажлын гүйцэтгэлийг үнэлэхгүйгээр 2,029.3 сая төгрөгийн сар, улирлын шагналт цалин олгосон байна. Энэ нь Эрдэнэс критикал мениралс ТӨҮГ-ын захирлын 2025 А/43 тушаалаар баталсан "Цалин хөлсний журам батлах тухай" журмын 3.6 "УРАМШУУЛАЛ: Үйлдвэрийн газрын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхжүүлэх зорилгоор сар, улирал бүр шагналт цалин болон жилийн үр дүнгийн урамшууллыг олгоно" гэж заасныг зөрчиж Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн өмчит үйлдвэрийн газрын захиргааны албан хаагчдын ажлын төлөвлөгөө түүний хэрэгжилтийг үндэслэж үр дүнг үнэлж, дүгнэн шагналт цалин тогтоох.

**Илрүүлэлт:** ТӨҮГ-ын баяжуулах фабрикийн дарга, ерөнхий инженер, бүтээмж хариуцсан менежер, хэлтсийн дарга зэрэг албан тушаалтнууд гадаад томилолтоор ажиллахдаа толгой компанийн удирдлагаас зөвшөөрөл аваагүй байна. Энэ нь Засгийн газрын 2025 оны 95 дугаар тогтоолоор баталсан дүрмийн 4.1.6.-д "Үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтан гадаадад албан томилолтоор ажиллах тохиолдолд нэгдлийн толгой компанийн гүйцэтгэх удирдлагаас зөвшөөрөл авч, түүний баталсан удирдамжийн дагуу ажиллана", 5.3-т "Үйлдвэрийн газрын Захирал, газар, хэлтэс, алба, цехийн дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнийг эрх бүхий албан тушаалтанд тооцно." гэж заасныг зөрчиж Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Эрдэнэс монгол ХХК-иас зөвшөөрөл авч, удирдамжийг батлуулж ажиллах.

#### **2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал:**

**Илрүүлэлт:** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 909.5 сая төгрөгийн 88 арга хэмжээг шууд худалдан авахаар төлөвлөснөөс тайлант оны эцэст 87.8 сая төгрөгийн 9 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1</sup>.2.3. "техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;" гэж заасныг зөрчиж Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид шууд худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд саад учруулахгүй, шуурхай, оновчтой зохион байгуулж, нэгжүүдийн хоорондын уялдааг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 13,818.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнг тооцолгүй урамшуулал олгосон	1	2,029,334.3					1	2,029,334.3				
Сүүлийн 3 жил хөдөлгөөн ороогүй бараа материал	1	2,882,544.1			1	2,882,544.1						
Томилолтоор ажиллахдаа зөвшөөрөл аваагүй	1	41,547.3					1	41,547.3				
Зорилгоос өөр нэрээр тендер зарласан, Хугацаандаа хэрэгжээгүй худалдан авалтад алданги тооцоогүй, Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд хяналт тавиагүй.	1	8,325,788.5			1	8,325,788.5						
Шууд худалдан авалтыг олон үе шаттай удаашралтай зохион байгуулж байна.	1	87,816.3					1	87,816.3				
Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөхгүй байна.	1	-			1	-						
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>13,367,030.5</b>			<b>3</b>	<b>11,208,332.6</b>	<b>3</b>	<b>2,158,697.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Бүтээмжийн менежер ажиллуулсан	1	451,154.1					1	451,154.1
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>451,154.1</b>					<b>1</b>	<b>451,154.1</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>451,154.1</b>					<b>1</b>	<b>451,154.1</b>



ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12

Дугаар 231-А2370448

Чингис хот

ХЭА-2026/4/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 5,774.2 сая төгрөгийн 24 арга хэмжээг нэмж, 16,701.3 сая төгрөгийн 51 арга хэмжээг хасаж, 10,926.6 сая төгрөгөөр бууруулан 3 удаа өөрчлөлт оруулсан, өмнөх оноос дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахгүй орхигдуулдаг, төсөвт өртгийн хэмжээг зөрүүтэй тусгадаг, төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөхгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.12-т "Батлагдсан төлөвлөгөөнд дараах тохиолдлоос өөр үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно", 2.12.2-т "энэ журмын 1.7-д заасан захиалагчийн тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл үүссэн" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэлгүй өөрчлөлт оруулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ТӨҮГ-ын захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Зоригтбат-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



**ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 12

Дугаар 232-А2370448  
ХЭА - 2026/4/НА - СТА - ТӨА

Чингис хот

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. "Үйлдвэрлэлийн болон ундны усны зориулалттай шугам хоолойн гэмтлийг засварлах ажил" нэртэй 210,870,000.00 (хоёр зуун арван сая найман зуун далан мянга) төгрөгийн арга хэмжээг тендер шалгаруулалтын нэрээс зөрүүтэйгээр ган хоолой болгон худалдан авсан байна.

2. Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтөөр оруулсан 1,150,000,000.00 (Нэг тэрбум нэг зуун тавин сая) төгрөгийн "Бутлагч алхтай экскаватор"-ыг гэрээний дагуу нийлүүлсэн боловч ажлын талбарт ажиллах боломжгүй эвдрэлтэй техник ирүүлсэнтэй холбоотойгоор, худалдах, худалдан авах гэрээ нь хэрэгжээгүй байна.

3. Тайлант онд 6,964,918,476.00 (зургаан тэрбум есөн зуун жаран дөрвөн сая есөн зуун арван найман мянга дөрвөн зуун далан зургаа) төгрөгийн 7 арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй, гэрээнд заасан алдангийг тооцоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-т "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх"; Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ."; 232 дугаар зүйлийн 232.6-д "Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ." гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авдаггүй, тендерт шалгарсан арга хэмжээний зориулалтыг

өөрчилж хэрэгжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ТӨҮГ-ын захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Зоригтбат-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12

Дугаар 233-А2371281  
ХЭА-2026/4/НА-СТА-ТӨА

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрийн бараа материалын дансны үлдэгдэлд 2,303,668.6 мянган төгрөгийн, Шижир Алт алтны үйлдвэрийн бараа материалын дансны үлдэгдэлд 578,875.5 мянган төгрөгийн нийт 2,882,541.1 мянган төгрөгийн бараа материалыг сүүлийн 3 жилийн хугацаанд эргэлтэд оруулаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 10/-т "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах," НББОУС 2-ийн 5-т "Бараа материал гэдэгт: а. бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулахаар эзэмшиж байгаа, б. ингэж борлуулахын тулд үйлдвэрлэлийн процесст байгаа. в. үйлдвэрлэлийн процесст эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа ... хөрөнгө юм." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын нөөцийг их хэмжээгээр бүрдүүлж, үр ашиггүй удаан хадгалдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Зоригтбат, ерөнхий нягтлан бодогч М.Цэнд-Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12

Дугаар 234-А/2360453

Чингис хот

ХЭА-2026/04/НА-СТА-ТӨА

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд бүтээмжийн менежер, хяналтын менежерээр 2 албан тушаалтныг томилж 451,154,105.00 (дөрвөн зуун тавин нэгэн сая нэг зуун тавин дөрвөн мянга нэг зуун таван) төгрөгийн цалин, шагнал, урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4. "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолын 5 дахь заалт "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, оновчтой тогтоох, удирдлагын зардал, орон тоог бууруулах зорилгоор зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах ..." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуулиар хориглосон орон тоог бий болгож, цалин, шагналт цалин олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригтбат-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН

